

Нийслэлийн мал эмнэлгийн газрын
даргын 2020 оны 04 дугаар...сарын
30-ны өдрийн А/26 дугаар...тушаалын
9 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Мал эмнэлгийн салбарын хууль тогтоомж, дүрэм журмын стандартыг хэрэгжүүлж, байнгын болон түр хяналтын цэгээр дамжин өнгөрөх мал, амьтны шилжилт хөдөлгөөний хорио цээрийн шаардлага, түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, гарал үүслийн баталгаажуулалтыг хангуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нийслэлийн Мал эмнэлгийн газар

Нэгжийн нэр:

Мал эмнэлгийн хяналт, эрсдлийн үнэлгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Мал эмнэлгийн хяналтын цэгийн хорио цээрийн улсын байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

БГД, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Мал эмнэлгийн салбарын хууль тогтоомж, дүрэм журмын стандартыг хэрэгжүүлж, байнгын болон түр хяналтын цэгээр дамжин өнгөрөх мал, амьтны шилжилт хөдөлгөөний хорио цээрийн шаардлага, түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, гарал үүслийн баталгаажуултыг хангуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Харьяа нутаг дэвсгэрт мал эмнэлгийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.
- 2.Хяналтын цэгээр дамжин өнгөрөх мал, амьтны шилжилт хөдөлгөөний хорио цээрийн шаардлагыг хангуулах, хяналт тавих, нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх.
- 3.Зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэлтийг удирдах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх.
4. Бусад чиг үүрэг.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г, Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Харьяа нутаг дэвсгэрт хууль тогтоомж мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс баримталж буй бодлогыг хэрэгжүүлж ажиллах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Г
	2.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх;		Г
	3.Салбарын хууль, тогтоомжийг сурталчилах, иргэн, хуулийн этгээдийг зөвлөгөө, мэдээллээр хангах;		Г
	4.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжиж байгаа практикийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх;		Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;	Нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдсэн байна.	Г
	2.Малын шилжилт хөдөлгөөний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах;		Г
	3.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс олгосон мал амьтны эрүүл мэндийн тодорхойлолтыг үндэслэн	Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий	Г



	мал эмнэлгийн гэрчилгээ олгож, цахим системийн бүрдүүлэлтэд баяжилт хийх;	эд, бүтээгдэхүүний хорио цээрийн шаардлага хангагдсан байна.	
	4.Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн технологи үйл ажиллагаатай холбогдсон хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах байнгын хяналт тавих;		Г
	5.Зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэх;	Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	6.Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, үр дүнг тооцох;		Г
	7.Мал, амьтны эрүүл мэндийн хууль, түүнд нийцүүлэн гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт зөрчиж халдварт өвчин тараасан тохиолдолд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг барагдуулах асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх;		Г
	8.Мал эмнэлгийн улсын байцаагчийн шийдвэр биелүүлээгүй тохиолдолд шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл зөрчлийг таслан зогсоох тухай санал дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;		Г
	1.Хуулиар харьяалуулсан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоосон хугацаанд прокурорын хяналтанд холбогдох ажиллагааг явуулах;		Г
3 дүгээр зорилтын хүрээнд	2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдийг холбогдох журмын дагуу хууль зүйн үндэслэлтэй бүрдүүлж, оролцогчийн эрх үүргийг хангаж ажиллах;	Г	



	<p>3.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгах, зардлыг нөхөн төлөхтэй холбоотой шийдвэрийг биелүүлээгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах, шаардлагатай бол шүүх хуралд оролцож нотлох;</p>	Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн хүрээнд явагдана.	Г
	<p>4.Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрч холбогдогчийн гаргасан гомдол, эсхүл хүчингүй болгох, өөрчлүүлэхээр прокурорын гаргасан дүгнэлтийн дагуу шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, тайлбар хүргүүлэх, нотлох;</p>		Г
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Байгууллагын дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцох;</p>	Төрийн үйлчилгээг чанартай, түргэн шуурхай хүргэж ажилласан байна.	Г
	<p>2.Дээд шатны байгууллага, удирдлагаас гаргасан шийдвэр, хурал, зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан Ажлын хэсэгт орж ажиллах;</p>		Г
	<p>3.Төрийн захиргааны албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхдээ мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх;</p>	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгосон байна.	Г
	<p>4.Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ, судалгааг холбогдох дээд шатны байгууллага, удирдлагад хүргүүлэх,</p>	Тайлан, мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв хийж хүргүүлсэн байна.	Г
	<p>5.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж биелэлт, хэрэгжилтийг тайлагнах;</p>	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулсан байна.	



	6.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу заасан хугацаанд архивт хүлээлгэн өгөх.	Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна.	Г
--	--	---	---

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй;	
Мэргэжил	Малын их эмч, мал эмнэл зүй;	
Мэргэшил	Төрийн албаны богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд, эсхүл мэргэжлээрээ ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> -мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; -судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудыг харьцуулан үнэлж, санал боловсруулах, танилцуулах; -бусад;
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> -албан үүргээ хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх; -хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; -тулгамдсан асуудлыг шийдвэрлэх саналыг боловсруулж, удирдлагад танилцуулах; -аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; -бусад;
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> -ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байдлаар бусдыг үлгэрлэх; -үйл ажиллагаандаа шинэлэг санааг нэвтрүүлэх, бусдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; -хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; -албаны үйл ажиллагааны шинэлэг үзэл санааг нэгжийн хамт олонд тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;
	Бусад	<ul style="list-style-type: none"> -англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; -багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусад таниулах; -орчин үеийн арга хэлбэрийг ашиглан мэдээллийг хүргэх;



		-албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; -компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;
--	--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Мал эмнэлгийн газрын дарга /улсын ахлах байцаагч/
- Мал эмнэлгийн хяналт, эрсдлийн үнэлгээний хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан
- Бусад хэлтэс, лабораторын эмч, мэргэжилтэн, байцаагч
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
.....
..... 3. БАТСҮЛД
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)
2019 оны 09 дугаар сарын 20-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19 10 02

Дугаар: 87

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН

Байгууллагын нэр:

НИЙСЛЭЛИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА А.НАРАНТУЯА

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

